



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/30

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” XV их наадмыг зохион байгуулахад хэрэглэгдэх бараа, материал хадгалах 40 тонн контейнерыг худалдан авах ажлыг иргэн П.Хишигбадрахтай шууд гэрээ байгуулж, худалдан авах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан барааг холбогдох стандарт, журам, зааврын дагуу хүлээлгэн өгөхийг (П.Хишигбадрах)-д даалгасугай.

3. Шаардагдах санхүүжилт 11,000,000 (арван нэгэн сая) төгрөгийг хавсралтаар баталж, орон нутгийн хөгжлийн сангийн “Алтаргана 2024” арга хэмжээний төлөвлөгдсөн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
...3 дүгээр сарын ...-ны өдрийн ... А.А. Будаг
захирамжийн хавсралт



Контейнер худалдан авах ажлын төсөв

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Контейнер	40 тонн	9,500,000	9,500,000
2	Тээвэрлэлтийн зардал	камаз	1,500,000	1,500,000
Нийт дүн			11,000,000	